

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД
ОРУУЛАХ КОМИССЫН ДҮГНЭЛТ

2025 оны 03 сарын 21-ны өдөр

Дугаар БА-087/2025

Улаанбаатар хот

Нэг. Удиртгал хэсэг

Монгол Улсын нийслэлийн Сүхбаатар дүүргийн 9 дүгээр хороонд баригдсан өндөр төвөгшилтэй ангиллын зорьтой 14 давхар 1 блок, 4 (дөрөв) агуулахтай, 92 (ерэн хоёр) айлын хүчин чадалтай үйлчилгээтэй орон сууцны зориулалттай барилга байгууламжид Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн 212 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн А/503 дугаар захирамжийн шийдвэрээр байгуулагдсан 14 гишүүний бүрэлдэхүүнтэй барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс 2025 оны 02 дугаар сарын 03-ны өдрөөс эхлэн 1 хоногийн хугацаанд ажиллан тухайн барилга байгууламж, түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийв.

Хоёр. Ерөнхий мэдээлэл

2.1. Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээний 2023/09/04 огноо; 0013516 БАЗГ2023/609 дугаар;

2.2. Барилга байгууламжийн зураг төслийн шифр дугаар: BSW-23/01

2.3. Захиалагч: Иргэн Боржигон овог, Дамбасэнгэ эцэг эхийн нэр, Азжаргал өөрийн нэр, ЧК65102861 регистрийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 18 дугаар хороо, 4-р хороолол, Ард аюушын өргөн чөлөө гудамж, 43 байр, 55 тоот, 99116488 холбоо барих утас, chinbat96@gmail.com цахим хаяг;

2.4. Барилгын ажлын ерөнхий гүйцэтгэгч: Тэлмүүнлхам Констракшн ХХК оноосон нэр, 1011003093 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 3554104 регистрийн дугаар, БУ32-378/22 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: Өвөрхангай аймаг, Хархорин хот, 2-р баг, Ганган-Орхон, Соёмбо, 3 тоот, 99116488 холбоо барих утас;

2.5. Барилгын ажлын туслан гүйцэтгэгч: Эрдэнийн шадар даанууд ХХК оноосон нэр, 9011445059 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5789141 регистрийн дугаар, Хаяг: Улаанбаатар, Баянгол дүүрэг, 6-р хороо, 10-р хороолол, 26 байр, 12 тоот, 99795620 холбоо барих утас;

Туслан гүйцэтгэгч: Шарвинт ХХК оноосон нэр, 9011445138 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5794153 регистрийн дугаар, БУ19-490/24 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 12 дугаар хороо, Булгийн 18, 839 тоот, 99119830 холбоо барих утас;

Шарвинт ХХК оноосон нэр, 9011013017 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 2768097 регистрийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 6

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
ГАЗАР

Барилга байгууламжийг ашиглалтанд
оруулах комисс

дугаар хороо, 10-р хороолол, Дилав хутагт жамсранжав, ХД 31, 1 тоот, 99114549 холбоо барих утас;

Стандарт суулгалт ХХК оноосон нэр, 9011865728 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 7033065 регистрийн дугаар, Хаяг: Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 24-р хороо, Яармаг, Наадамчдын зам, 305, 45 тоот, 98090977 холбоо барих утас;

Электрикал бюлдинг нетворк ХХК оноосон нэр, 9011731015 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 6282512 регистрийн дугаар, Хаяг: Улаанбаатар, Баянгол дүүрэг, 8-р хороо, 4 хороолол, 14, 97 тоот, 88073568 холбоо барих утас;

2.6. Барилга байгууламжийн зураг төсөл зохиогч байгууллага: Бизайн ХХК оноосон нэр, 9011214005 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5336058 регистрийн дугаар, ЗТ12-56/22 зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 6 дугаар хороо, АВ центр, 903 тоот, 91919022 холбоо барих утас;

2.7. Барилга байгууламжийн ашиглагч, өмчлөгч байгууллага: Тэлмүүнлхам Констракшн ХХК оноосон нэр, 1011003093 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 3554104 регистрийн дугаар, Хаяг: Өвөрхангай аймаг, Хархорин хот, 2-р баг, Ганган-Орхон, Соёмбо, 3тоот, 99116488 холбоо барих утас;

2.8. Барилга байгууламжийн төлөв байдал: **Шаардлага хангасан.**

Гурав. Дүгнэлтийн хэсэг

✓ Барилга байгууламжийг ашиглалтад оруулах:

- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангасан барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул

□ Барилга байгууламжийг ашиглалтад оруулахаас татгалзах:

- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангаагүй, барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдээгүй, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаагүй тул

- Заасан хугацаанд үүрэг даалгаврын биелэлт хангаагүй тул

3.1.Энэ өндөр төвөгшилтэй ангиллын зоорьтой 14 давхар 1 блок, 4 (дөрөв) агуулахтай, 92 (ерэн хоёр) айлын хүчин чадалтай үйлчилгээтэй орон сууцны зориулалттай барилга байгууламж түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийж, барилгын ажлын гүйцэтгэл, чанарт үнэлгээ, дүгнэлт өгсний үндсэн дээр комиссоос ДҮГНЭСЭН нь:

ХЯНАЛТ ШАЛГАЛ
ГАЗАР

Барилга байгууламжийг ашиг
орлуулах комисс

Энэ барилга байгууламжийн барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан гэж үзээд ашиглалтад оруулах нь зүйтэй гэж дүгнэв.

3.2. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах болсонтой холбогдуулан захиалагч, гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч байгууллагуудад даалгах нь:

а) барилга байгууламжийн иж бүрэн баримт бичгийн эх хувийг архивт, үлдэх хувийг ашиглагч буюу өмчлөгч, эзэмшигч байгууллагад ... хоногийн дотор багтаан шилжүүлэх;

б) барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаанд ашиглалтын хэвийн нөхцөлийг хангах болон уг хугацаа дуусгавар болохтой холбоотой хууль тогтоомжид заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх;

3.3. Ашиглагч байгууллагад:

а) барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацааг дуусгавар болгоход оролцох;

б) барилга байгууламжийн хувийн хэргийг хөтөлж эхлүүлэх;

в) барилга байгууламжийн хэвийн ашиглалттай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг үүгээр даалгаж байна.

3.4. Комиссын акт 3 хуудас, хуралдааны тэмдэглэл 6 хуудас, комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн жагсаалт 28 хуудас материал болон барилга байгууламжийн бичиг баримтын жагсаалт материалыг дүгнэлтэд хавсаргаж байна.

Дөрөв. Дүгнэлтийн баталгаажуулалт

4.1. Өндөр төвөгшилтэй ангиллын зорьтой 14 давхар 1 блок, 4 (дөрөв) агуулахтай, 92 (ерэн хоёр) айлын хүчин чадалтай үйлчилгээтэй орон сууцны зориулалттай барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүгнэлт гаргасан:

Сүхбаатар дүүргийн 9 дүгээр хороо, Иргэн Д.Азжаргалын захиалгатай, зорьтой 14 давхар 1 блок, 4 (дөрөв) агуулахтай, 92 (ерэн хоёр) айлын үйлчилгээтэй орон сууцны барилга

Комиссын дарга:

Хяналт шалгалтын газрын

Барилга байгууламжийн ашиглалт,

бүртгэлийн хэлтсийн даргын албан

үүргийг түр орлон гүйцэтгэгч



(А.Мөнгөн)

Нарийн бичгийн дарга:

Захиалагч Иргэн

(Д.Азжаргал)

Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын үүрэг даалгаврын биелэлтийн хуудасны хамт хүчинтэй.



СҮХБААТАР ДҮҮРГИЙН 9 ДҮГЭЭР ХОРОО, ИРГЭН Д.АЗЖАРГАЛЫН ЗАХИАЛГАТАЙ,
ЗООРЬТОЙ 14 ДАВХАР 1 БЛОК, 92 АЙЛЫН ҮЙЛЧИЛГЭЭТЭЙ ОРОН СУУЦНЫ
БАРИЛГЫГ АШИГЛАЛТАНД ОРУУЛАХ КОМИССЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2025 оны 02 дугаар сарын 03

Улаанбаатар хот

Сүхбаатар дүүргийн 9 дүгээр хороо, Иргэн Д.Азжаргалын захиалгатай, зоорьтой 14 давхар 1 блок, 92 айлын үйлчилгээтэй орон сууцны барилгыг ашиглалтанд оруулах комисс 2025 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн 13:00 цагт 14 гишүүний бүрэлдэхүүнтэй эхэлж, 15:00 цагт дуусав.

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
ГАЗАР

Газарга байгууламжийг ашиглалтанд
оруулах комисс

Хуралд:

1. Хяналт шалгалтын газрын Барилга
Байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн даргын
албан үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Мөнгөн
2. Хяналт шалгалтын газрын Барилгын стандарт,
аюулгүй байдлын хяналтын хэлтсийн, Барилгын
техникийн хяналтын улсын ахлах байцаагч Ц.Алтансүх
3. Хяналт шалгалтын газрын Дэд бүтцийн стандарт
хяналтын хэлтсийн Эрчим хүчний хяналтын
улсын ахлах байцаагч З.Очирпүрэв
4. Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК,
Техникийн хяналтын инженер Б.Цэрэннадмид
5. Улаанбаатар дулаан сүлжээ ТӨХК,
БТТ-ын ахлах инженер Э.Ундрахцогт
6. Ус сувгийн удирдах газар,
Хэрэглэгчид үйлчлэх албаны менежер Б.Жамбалцанжид
7. Мэдээлэл холбоо сүлжээ ТӨХК,
Технологийн удирдлага төлөвлөлтийн газар
Чанар хяналтын хэлтсийн Мэргэжилтэн Н.Даваадэмид
8. Онцгой байдлын ерөнхий газар,
Зураг төслийн хяналтын тасгийн дарга,
Дэд хурандаа Б.Мягмаржав
9. Барилгын хөгжлийн төв, Барилга барилгын материалын
үйлдвэрлэлийн хэлтсийн мэргэжилтэн О.Ундрах
10. Үндэсний төв архив, Зураг төслийн
баримтын архивын ахлах архивч Б.Оюунжаргал
11. Тэлмүүн Орд ХХК-ийн захирал Х.Гантүшиг
12. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийг хамгаалах
Байгууллага, хүртээмжийн үнэлгээний ажилтан Н.Эрдэнэтөгс
13. Зураг төсөл зохиогч Бизайн ХХК-ийн
барилга бүтээцийн мэргэшсэн инженер Ц. Насанхутаг
14. Захиалагч иргэн Д.Азжаргал
15. Тэлмүүнлхам Констракшн ХХК-ийн захирал Д.Азжаргал

ИРЦИЙН БАЙДАЛ

- Мэдэгдэл хүлээн авсан – 15
- Хуралд оролцож санал гаргасан – 15

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Сүхбаатар дүүргийн 9 дүгээр хороо, Иргэн Д.Азжаргалын захиалгатай, зоорьтой 14 давхар 1 блок, 92 айлын үйлчилгээтэй орон сууцны барилгыг ашиглалтанд оруулах шаардлага хангасан эсэх талаар хэлэлцэв.

СОНССОН НЬ:

Комисст ажилласан гишүүд барилга байгууламжийн зураг төсөл, баримт бичиг, барилгын ажлын гүйцэтгэлийг хянаж танилцаад дараах саналуудыг гаргав.

Хяналт шалгалтын газрын Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтсийн Барилгын техникийн хяналтын улсын ахлах байцаагч **Ц.Алтансүх:**

- Техникийн давхарт у1, х2, у3, х2 у1, х5, у3, х5 х2 – х5 хооронд ачаалал нэмэгдүүлсэн
- Зоорь, 1-14 давхарт төлөвлөлт өөрчлөгдсөн
- Х2 у6 аас х5 у6 хооронд саравч хийхдээ чигжээ дутуу, усны хаялага хийгдээгүй
- Техникийн давхрын дээврээс буух усны хаялага хийх.
- Хөрсний уснаас хамгаалах арга хэмжээг нөхөж үзүүлэх зоорийн давхарт ч1 тэнхлэгийн дагуу ус нэвчсэн байдалтай байв.
- Батлагдсан зураг төсөл, БАЗГ хоорондох хугацаанд тайлбар ирүүлэх
- Дутуу ажлыг гүйцээх (барилгын засал чимэглэлийн ажлыг)
- Давхар бүрт айл хоорондын хаалга мөргөлдөж буй байдалд тайлбар ирүүлэх
- Өөрчлөлтийн (гүйцэтгэлийн) зураг төслийг боловсруулан баталгаажуулах
- Тоглоомын талбайн байршил өөрчлөгдсөн байдалд тайлбар ирүүлэх.
- 1-р давхрын төлөвлөлт өөрчилсөн байдалд зохиогч, захиалагч тайлбар ирүүлэх.

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай байна.

Хяналт шалгалтын газрын Дэд бүтцийн стандарт хяналтын хэлтсийн Эрчим хүчний хяналтын улсын ахлах байцаагч **З.Очирпүрэв:**

- Гадна дулаан, цэвэр бохир усны шугам сүлжээг, ХБХСГ, НАЗГ, ЦТүгээх зэрэг байгууллагуудтай бүрэн зөвгилцөж батлуулах
- Огтолгооны худаг цэвэрлэх, өөрийн шугам будаж дулаалах
- ГД-ны зурагт заагдсан 2-р худаг зургийн дагуу угсрах, Үл хөдлөх тулгуур угсарсан ил далд ажлын акт мөн ГД, ЦБУ угсралтын сорилт туршилтын акт шалгуулах
- Узелийн халаалтын насосны дуу чимээг багасгах арга хэмжээ авах узель, нөөцийн савны өрөөнд ус зайлуулах трап хийх
- Халаалтын босоо шугаманд блансын хаалт угсрах
- Халаалтын айлуудын коллекторт хий авагч угсрах



- Алчуур хатаагчийн төгсгөлүүдэд хий авагч хийх
- Айлуудын босоо шугаманд үзлэгийн ревиз хийх
- Гадна дулаан ЦБУ ны шугамууд мэдээллийн санд актаар оруулах
- Усны нөөцийн сав ариутгал хийлгэж, уснаас дээж авч НЭМГ-ийн улсын байцаагчаар дүгнэлт гаргуулах
- Техникийн давхрыг айл өрхөөр ашиглахгүй баталгаа гаргах

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай байна.

Улаанбаатар дулаан сүлжээ ТӨХК, ахлах инженер **Э.Ундрахцогт**:

- Гадна дулааны ДХ 1-р худаг цэвэрлэх
- ДХ 2-р худаг хийгдээгүй талаар зураг зохиогч гүйцэтгэгч нар тайлбар албан бичиг ирүүлэх
- Узелийн халаалт болон ХХУ-ний насосны дуу чимээ багасгах дээр арга хэмжээ авч дууг багасгах
- Халаах хэрэгслүүд дээр термастат винтель суурьлуулах

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай байна.

Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК, Техникийн хяналтын инженер **Б.Цэрэннадмид**:

- ЕОС-т хаяг бичиглэл схем заавар байршуулах мөн айлуудын тавцан суурьлуулах
- Цэвэр усны нөөцийн савны өрөөнд хүрээ газардуулга хийж тоноглолыг холбох
- Техникийн давхарт лифт, агааржуулалтын өрөөнд хүрээ газардуулга хийж тоноглолуудыг холбох
- Айл өрхийн тоолуурыг техникийн нөхцөлийн дагуу ухаалаг тоолуураар солих
- Аянгын торыг зэврэлтээс хамгаалж будах
- АВР – ын самбарын тоолуур тооцоонд ороогүй тул СБХҮТ-д захиалга өгч бүртгүүлэх
- ЭХ-ний тухай хуулийн 30.1.13 заалтын дагуу гадна шугам сүлжээг хангагч байгууллагад шилжүүлэх хүсэлт ирүүлэх
- Зарим айлуудын ариун цэврийн өрөөнд разеткууд ус чийг хамгаалалт хийгдээгүй байгааг гүйцээх
- Аянгын газардуулгыг хэмжүүлж протокол шалгуулах

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай байна.

Мэдээлэл холбоо сүлжээ ТӨХК, Технологийн удирдлага төлөвлөлтийн газар, Чанар хяналтын хэлтсийн мэргэжилтэн **Н.Даваадэмид**:

- Холбооны техникийн өрөөг хаягжуулах
- Зургийн дагуу дүрст домофон систем суурьлуулаагүй тайлбар бичиг өгөх (voice харилцууртай байна)
- Дотор холбоо дохиоллын актыг нөхөж үзүүлэх

НАЛТ ШАЛГА
ГАЗАР

байгууламжийг
оруулах ком

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай байна.

Ус сувгийн удирдах газар, Хэрэглэгчид үйлчлэх төвийн менежер **Б.Жамбалцанжид:**

- Гадна цэвэр, бохир усны шугамын ажлын зургийг холбогдох байгууллагуудаар батлуулах, өөрчлөлтийг зургийн автораас тайлбар дүгнэлт гаргаж өгөх
- Ил далд ажлын актыг баталгаажуулах шалгуулах
- Усны нөөцийн санг халдваргүйжүүлээт хийгдсэн акт дүгнэлтийг мөн усны шинжилгээний дүгнэлтийг шалгуулах
- Гадна ЦУХ-т галын гидрант суурилуулах
- Тэлмүүн Орд ХХК-тай бохир нийлүүлэх зөвшилцсөн албан бичиг шалгуулах
- Оймон ХХК тай зөвшилцсөн албан бичиг шалгуулах

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай байна.

Онцгой байдлын ерөнхий газар, Зураг хяналтын тасгийн дарга, Дэд хурандаа **Б.Мягмаржав:**

- Гал түймрийн үеийн утаа зайлуулах болон агаар өгөх системийг шалгаж актаар баталгаажуулах
- Орон сууцны 1 болон техникийн давхарт өөрчлөлтийн зураг гаргаж баталгаажуулах

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай байна.

Үндэсний төв архив, Зураг төслийн баримтын архивын ахлах архивч **Б.Оюунжаргал:**

- Архивд баримтаа баримт бүрдүүлэх нийтлэг жагсаалтын дагуу бүрэн бүрдэлтэй өгөх
- БУ-н ил далд ажлын акт гэрэл зураг хавсаргаж дотоод товъёог үйлдэх
- Гэрээ болон хувийн хэрэгт дотоод товъёог үйлдэх бүрдэл хангах
- БУ-н тэмдэглэл дэвтэр гарын үсэг бүрдэл хангах ажлын нэрээр хаягжуулалт хийж өгөх
- Гадна дотор ажлын зургийн бүрдлийн дагуу бүрэн хүлээлгэж өгөх

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай байна.

Барилгын хөгжлийн төв, Барилга барилгын материалын үйлдвэрлэлийн хэлтсийн мэргэжилтэн **О.Ундрах:**

- Техникийн давхрын дээврийн усны хаялгыг дээврээс дээш 30см хүртэл буулгах
- Гонхны дээврийн усны хаяглага хийгдээгүй байна. /хийх/
- Зураг төсөлд цонх 3 давхар шиллэгээтэй гэж тусгасан байвч 2 давхар шилтэй хийсэн. Үүн дээр зохиогч байгууллага дулаан техникийн тооцоо гаргаж хангаж байгаа эсэх талаар тайлбар албан бичиг ирүүлэх
- G сууцны лифтний хананд дуу тусгаарлагч хийсэн акт, фото зураг нөхөж үзүүлэх
- Суурь болон зоорийн давхарт ус тусгаарлагч хийсэн акт, фото зураг нөхөж үзүүлэх

- Барилгын тухай хуулийн 5.7.1-д заасны дагуу норм, нормативын төлбөрийг тооцуулж төлөх
- Тагтны шалыг зураг төслийн дагуу бүрэн хийж дуусгах

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийг хамгаалах Байгууллага, хүртээмжийн үнэлгээний ажилтан **Н.Эрдэнтөгс:**

- Гадна автомашины зогсоолуудад явган хүний зам талд нь автомашины дугуй цохигч буюу хаалтууд хийж өгөх
- Үйлчилгээний хэсгийн ариун цэврийн өрөөнд 1 суултуур угаалтуур шээлтүүрийг ХБИ-д зориулсан стандарт тоноглолоор тоноглоно.

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай байна.

Ашиглалт хариуцах байгууллага, Тэлмүүн Орд ХХК захирал **Х.Гантүшиг:**

- Ус дулааны дамжуулах төвийн ХХУ-ны өгөх шугам дээр даралт хэмжих хэрэгсэл /манометр/ суурилуулах
- Цэвэр усны нөөцийн савыг мэргэжлийн байгууллагаар цэвэрлүүлж ашиглалтанд оруулж ашиглалтын компанид хүлээлгэж өгөх

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай байна.

Зураг төсөл зохиогч Бизайн ХХК-ийн инженер **Ц.Насанхутаг:**

- Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай байна.

Захиалагч иргэн **Д.Азжаргал:**

- Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай байна.

Гүйцэтгэгч Тэлмүүнлхам Констракшн ХХК-ийн захирал **Д.Азжаргал:**

- Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай байна.

Хяналт шалгалтын газрын Барилга Байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн даргын албан үүргийн түр орлон гүйцэтгэгч **А.Мөнгөн:**

- Хүүхдийн тоглоомын талбайн ерөнхий шаардлага 2022 онд батлагдсан хотын стандартыг хангаж батлагдсан зургийн дагуу хийх /UCS1405B:2022/
- Гадна тохижилт, ногоон байгууламжыг дулааны улиралд гүйцэт хийх албан бичиг, баталгаа ирүүлэх
- Хүүхдийн тоглоомын талбайг батлагдсан ажлын зургийн дагуу байршуулж загвар зурагт заасны дагуу бетон шалыг резинен хучилтаар хийж аюулгүй байдлыг
- Дотор хог зайлуулах хоолойг дотор ханыг галаас хамгаалах тоноглолоор тоноглох төмөр хаалга хийх хаалганы онгойлтыг стандартын дагуу болгож өөрчилж, фото зургаар баталгаажуулах

- Зоорийн давхар луу орох налуу замд аюулгүй байдлыг хангасан хаалт хашлага хийх

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Сүхбаатар дүүргийн 9 дүгээр хороо, Иргэн Д.Азжаргалын захиалгатай, зорьтой 14 давхар 1 блок, 92 айлын үйлчилгээтэй орон сууцны барилгыг гишүүдийн өгсөн үүрэг даалгаврын хангуулах, биелэлтээр комиссын дүгнэлт үйлдэх, баталгаажуулах байнгын ашиглалтанд оруулахаар шийдвэрлэв.

Танилцсан:

Хяналт шалгалтын газрын
Барилга байгууламжийн ашиглалт,
бүртгэлийн хэлтсийн даргын албан
үүргийг түр орлон гүйцэтгэгч



(А.Мөнгөн)

Тэмдэглэл хөтөлсөн:

Захиалагч Иргэн

(Д.Азжаргал)

